

БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Донорын тухай (шинэчилсэн найруулга) хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн “амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах” үндсэн эрхийг эдлэхээр тунхагласан.

Монгол Улсын Их Хурлаас Донорын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан бөгөөд 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр уг хуульд өөрчлөлт орсон хэдий ч одоогийн мөрдөгдөж буй зарим зохицуулалт нь өнөөдрийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангахгүй байгаа тул зөхицуулагдаагүй зарим харилцааг зохицуулах шаардлага үүссэн болно.

1.2.Практик шаардлага

Монгол Улсад эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж, 2006 онд бөөр шилжүүлэн суулгах анхны мэс заслыг амжилттай хийснээс хойш 2021 оны 12 дугаар сарыг хүртэлх хугацаанд 250 иргэнд бөөр (211 иргэнд амьд донороос, 39 иргэнд амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгасан), 181 иргэнд элэг (160 иргэнд амьд донороос, 21 иргэнд амьгүй донороос элэг шилжүүлэн суулгасан), 24 иргэнд ясны чөмөгний үүдэл эс, 24 иргэнд нүдний эвэрлэг, 735 иргэнд арьс, 51 иргэнд шөрмөс, 373 иргэнд үр шилжүүлсэн суулгах эмчилгээг тус тус амжилттай хийгээд байна.

Донорын тухай (шинэчилсэн найруулга) хуульд Монгол Улсын 25 насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр донор болохыг зөвшөөрөх тухай заасан нь амьдралд төдийлөн нийцэхгүй байна. Донорын тухай хуулийн 9 дүгээр зүйлд эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах алба байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, эрх, үүргийг нь тодорхойлсон. Тус алба байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэлх хугацаанд эс, эд, эрхтний донорын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж ирсэн бөгөөд дараах асуудлыг зохицуулах шаардлага үүсээд байна.

Уг хуульд зааснаар 25 насанд хүрээгүй амьд болон амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн авах, суулгах боломжгүй байгаа нь эмчлүүлэгчийн өвчин улам даамжрах, биеийн байдал хүндрэх, цаашлаад амь нас эрсдэх эрсдэлийг бий болгож байна.

Тухайлбал, Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээс хийсэн судалгаанд АНУ, ОХУ, Турк, Энэтхэг улсад 18 насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр эд, эрхтний донор болохыг зөвшөөрсөн бол Сингапур улс 21 насанд хүрсэн иргэн эд, эрхтний донор болохыг хуулиараа зөвшөөрчээ. Манай улсын хувьд донор болох насны доод хязгаар бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны явцад гарч болох ёс зүйн хэм хэмжээтэй холбогдсон харилцааг зохицуулах, нарийн төвөгтэй олон асуудлуудыг шийдвэрлэх үүрэг бүхий эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороог эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулах шаардлага тулгарч байна.

Түүнчлэн эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, холбогдох тоо баримтыг цуглуулж, хадгалах нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан /DATA бааз/-г Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба ажиллуулж байгаа бөгөөд тус мэдээллийн сангийн үйл ажиллагааг зохицуулах журмыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч Донорын тухай хуульд нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, ажиллуулах талаар хуульчлаагүй тул захиргааны хэм хэмжээний актаар бүртгэхээс татгалзсан болно.

Дэлхийн олон улс оронд (Австрали Улсад “National Donate Life Family Support Service NDFSS”, АНУ-д “Center of Organ Recovery and Education” түүнээс хэрэгжүүлдэг “Gift of Life Donor Program” болон “Organ Donation Grief Counseling Program”, БНСУ-д “KODA” буюу “Korean Organ Donation Agency”) донорын ариун үйл хэргийг таниулах, ухамсарлуулан ойлгуулах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг төвүүд ажилладаг бөгөөд энэ ажлын хүрээнд бусдад эс, эд, эрхтний донор болж буян үйлдэж, хүний амь нас, эрүүл мэндийг аврах үйл хэрэгт юугаар ч үнэлж болохгүй хувь нэмрээ оруулсан амьгүй донорын гэгээн дурсгалыг хүндэтгэх, гэр бүлд нь хүндэтгэл илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг, туслалцаа үзүүлдэг байна.

Эрүүл мэндийн байгууллагуудаас жил бүр “Донорыг хүндэтгэх өдөрлөг”, “Танд баярлалаа” зэрэг олон нийтийг хамруулсан арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд амьгүй болон амьд донор, цусны доноруудад хүндэтгэл үзүүлж, талархал илэрхийлж, урамшуулан алдаршуулдаг байна.

АНУ-д унаа, байр, хоол болон хөдөлмөр эрхлээгүй үед цалин хөлс олгох, асрах зардал, үзлэгийн төлбөр болон татварын хөнгөлөлт үзүүлдэг бол Солонгос Улсад (Internal Organs Transplant Act, Chapter 3-2 Article 27-2 Assistance for Organ Donor, etc.) амьгүй донорт оршуулгын зардал, амьд донорт эмчилгээний зардал, цалинтай чөлөө, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгдөг байна.

Иймээс манай улсын хувьд амьд донорт болон амьгүй донорын гэр бүлд дэмжлэг мөнгөн туслалцаа үзүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Өнөөдрийг хүртэл төрөөс амьгүй донорын гэр бүлд ямар нэг дэмжлэг туслалцаа үзүүлж байгаагүй бөгөөд цаашид оршуулгын тэтгэмж, нас барсан

даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд үзүүлэх тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага гарч байна.

Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанаас тархины үхэлтэй өвчтөний гэр бүлтэй уулзалт хийж, эс, эд, эрхтний донор болгох тухай хүсэлтийг тавихад тэдний зүгээс ямар нэгэн дэмжлэг тусалцаа өгөх эсэх, ялангуяа оршуулгын зардалд дэмжлэг үзүүлэх эсэхийг 95 хувь нь асууж байсан бөгөөд төрөөс дэмжлэг үзүүлэх зохицуулалт байхгүй гэсэн хариултыг сонсоод, 13 гэр бүл донор болгохоос татгалзаж байсан болно.

Япон Улсад ч гэсэн амьгүй донорын гэр бүлийн гишүүдээс хамгийн их асуудаг асуултад энэ асуулт ордог байна.

Мөн хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төр хариуцдаг эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Цус, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбогдох хариуцлагыг Эрүүгийн хуульд хүндрүүлж зүйлчилсэн байна. Тухайлбал, Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн Тусгай ангийн 15.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “1.Эмнэлгийн мэргэжилтэн хүний цус, эс, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэсэн, шилжүүлэн суулгасны улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заасан нь хүний алтан амийг аврах зайлшгүй шаардлага үүссэн, тээвэрлэх боломжгүй, цаг хугацаа хормоор хэмжигдэж байгаа үед хөдөө орон нутаг, малын бэлчээр, айлын гэрт буюу шаардлага хангаагүй нөхцөлд цус сэлбэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэнийхээ төлөө хүнд гэмт хэрэг үйлдсэнээр зүйлчлэгдэж, ял авахаар заажээ.

Түүнчлэн Монгол Улс төдийгүй дэлхийн аль ч улс оронд эс, эд, эрхтнийг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэж, шилжүүлэн суулгах боломжгүй юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй болгох, ёс зүйн хороо болон нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, донор, түүний гэр бүлд олгох санхүүгийн болон бусад дэмжлэг, тусалцааг тодорхой болгох, хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төр бүрэн хариуцах зэрэг харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу боловсруулсан бөгөөд Донорын тухай хууль болон хамт өргөн мэдүүлэх хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгана:

1.“Монгол Улсын 21 насанд хүрсэн иргэн сайн дурын үндсэн дээр эрхтнээ бусдад шилжүүлэн суулгах” гэж өөрчлөх.

2.Эс, эд, эрхтний донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулж, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах.

3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн ёс зүйн хороог байгуулах, тус хорооны дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.

4.Нийгмийн даатгалын сангаас амьгүй донорын оршуулгын тэтгэмжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

5.Амьд донорыг жилд нэг удаа дотоодын рашаан сувилалд үнэ төлбөргүй сувилуулах.

6.Хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг төр хариуцсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан амьд явах, эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндээ хамгаалуулах үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ.

7.Эрүүгийн хуулийн 15.4 дүгээр зүйлийг хүчингүй болгох.

8.Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай, Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хүүхдэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцаж байгаа тул хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төсөв, санхүүгийн ямар нэгэн нэмэлт зардал шаардахгүй болно.

Хуулийн төсөл батлагдсанаар эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний хүрээ нэмэгдэж, гадаадын улс оронд тусламж, үйлчилгээ авах иргэдийн тоо буурч, иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх хангагдана.

Хууль зүйн хувьд Донорын тухай хуулийн эрх зүйн орчин улам сайжрах болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуультай нийцсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.